



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 30 өдөр

Дугаар A/146

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан
Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Гүйцэтгэх захирлын 2022 оны А/82 тоот тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо”-ны хэрэгжилтийг хангах үүрэг бүхий зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Ерөнхий инженер

Нарийн бичгийн дарга:

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй
байдлын хэлтсийн дарга

Гишүүдэд:

- Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга
- Захиргаа, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга
- Төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Захиалагчийн хяналтын хэлтсийн дарга
- Харуул, хамгаалалтын хэлтсийн дарга
- Аж ахуй, кемп, үйлчилгээний хэлтсийн дарга
- Статистик, систем хөгжүүлэлтийн хэлтсийн дарга
- Зураг төсөл, технологийн хэлтсийн дарга
- Хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Зам, барилгын хэлтсийн ахлах механик инженер
- Дохиолол холбоо, эрчим хүчиний хэлтсийн эрчим хүчиний ахлах инженер
- Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын ахлах инженер
- Ачаа тээвэр, логистикийн хэлтсийн Тээвэрлэлт, гэрээ, тариф хариуцсан инженер
- Тавантолгой өртөөний дарга
- Гашуун сухайт өртөөний дарга
- Зүтгүүрийн депогийн дарга
- Вагоны аж ахуйн хэлтсийн ахлах инженер

0220758

2.Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/114 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам”-ыг мөрдлөг болгож, Орон тооны бус зөвлөлийг 14 хоног тутам хуралдуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг зөвлөлийн Нарийн бичиг, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хэлтсийн дарга /Д.Хишигдорж/-д үүрэг болгосугай.

3.Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.6-д заасны дагуу олгохыг нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга /Г.Жаргалсайхан/-д зөвшөөрсүгэй.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/61 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер /Б.Болор-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.УДААНЖАРГАЛ